



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/165

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар улсын нөөцөд хадгалагдаж байгаа өвсийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр, малын тэжээлийг 50 хувиар хямдруулан өвөлжилт хүндэрсэн аймаг сумдын малчдад олгох асуудлыг шийдвэрлэсний дагуу сумдад олгох хуваарийг нэгдүгээр, зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдах зөрчил гаргуулахгүй байх зорилгоор хяналт тавих ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Улсын нөөцөөс 50 хувийн хямдралтай үнээр олгох малын тэжээлийн үнийг Онцгой байдлын ерөнхий газрын 100900031005 тоот дансанд төвлөрүүлэн, буцалтгүй тусламжаар олгож буй өвс, хөнгөлсөн үнээр олгож байгаа тэжээлийг малчдад шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, зарцуулалтын тайланг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлагаар ханган илтгэж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /онцгой байдлын хурандаа Д.Батжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 764

УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ААС
 ҮНЭГҮЙ ӨВС, ХЯМДАРСАН ТЭЖЭЭЛ ОЛГОХ ХУВААРЬ

Аймгийн Засаг даргын 2017 оны
 дугаар сарын 25 өдрийн 41/А
 дугаар захирамжийн хавсралт

№	Цэгийн нэр	Сумдын нэрс	Өвс /2016 он, боодол 4400 төг/		Хивэг /2016 он/ 50хувь хямдарсан			
			тн	боодол	тн	шуудай	үнэ	
1	Бэрхийн өвс тэжээлийн цэг	1	Хэрлэн	16	500	10	400	1,897,500
		2	Баян-Овоо	10	500	10	400	1,897,500
		3	Батноров	10	500	10	400	1,897,500
		4	Бэрх	10	500	5	200	948,750
		5	Баянхутаг	10	500	10	400	1,897,500
		6	Галшар	10	500	5	200	948,750
		7	Мөрөн	10	500	10	400	1,897,500
		8	Өлзийт	10	500	5	200	948,750
		9	Норовлин	20	1000	10	400	1,897,500
		10	Жаргалтхаан	-	-	10	400	1,897,500
		11	Онцгой комисс	20	1000	15	600	2,846,250
	Бүгд	120	6000	100	4000	18,975,000		
2	Шар талын үүрийн цэг	1	Дадал	14	700	10	400	1,897,500
		2	Норовлин	10	500	-	-	-
		3	Баян-Аурага	14	700	10	400	1,897,500
		4	Баянхутаг	6	300	-	-	-
		5	Мөрөн	6	300	-	-	-
		6	Батноров	10	500	-	-	-
		7	Бэрх	6	300	-	-	-
		8	Жаргалтхаан	6	300	-	-	-
		9	Цэнхэрмандал	6	300	-	-	-
		10	Хэрлэн	6	300	-	-	-
		11	Гурванбаян	10	500	3	120	569,250
		12	Баян-Овоо	10	500	-	-	-
		13	Өмнөдэлгэр	16	800	7	280	1,328,250
		14	Батширээт	16	800	10	400	1,897,500
		15	Биндэр	12	600	10	400	1,897,500
		16	Онцгой комисс	12	600	-	-	-
	Бүгд	160	8000	50	2000	9,487,500		
3	Хэрлэнбаян- Улааны өвс тэжээлийн цэг	1	Дэлгэрхаан	20	1000	5	200	948,750
		2	Хэрлэнбаян-Улаан	10	500	5	200	948,750
		3	Бор-Өндөр	20	1000	10	400	1,897,500
		4	Баянмөнх	20	1000	10	400	1,897,500
		5	Дархан	20	1000	10	400	1,897,500
		6	Цэнхэрмандал	20	1000	10	400	1,897,500
		7	Жаргалтхаан	20	1000	-	-	-
		8	Онцгой комисс	20	1000	-	-	-
	Бүгд	150	7500	50	2000	9,487,500		
	Нийт дүн	430	21500	200	8000	37,950,000		

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
дарга:

Д.Батжаргал

-Онцгой байдлын газрын дарга
онцгой байдлын хурандаа

Гишүүд:

Л.Бат-Октябрь

-Засаг даргын тамгын газрын
Хууль зүйн хэлтсийн дарга

О.Ганбат

-Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн хурандаа

Э.Мөнх-Эрдэнэ

-Хөрөнгө оруулалт, Хөгжлийн
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
дарга

Ж.Энх-Амгалан

-Хүнс хөдөө аж ахуйн газрын
дарга

Б.Сүнгээ

-Мэргэжлийн хяналтын газрын
дарга